



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/764

Булган сум

**Орон нутгийн өмчийн газрын дүрэм, бүтэц,
орон тоог шинэчлэн батлах тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоол, 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол, 2023 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 312 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн газрын дүрмийг 1 дүгээр, бүтэц орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд шаардагдах төсвийг 2024 оны төсөвт тусгаж батлуулахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор аймгийн засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/116 дугаар захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг дагын 2023 оны
11 сарын 13-ны өдрийн 1764 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн акт, энэхүү дүрмээр зохицуулагдана.
- 1.2. Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн талаарх төрийн бодлогыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг эрхлэх үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх нэгж агентлаг мөн.
- 1.3. Газрыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан тогтоол шийдвэрийг үндэслэн Засаг дарга шийдвэрлэнэ..

ХОЁР. ӨМЧИЙН ТАЛААР ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Газар нь төрийн болон орон нутгийн өмчтэй холбогдох хууль тогтоомж, УИХ, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавина.
- 2.2. Газар нь нутгийн захиргааны байгууллагаас баримталж буй бодлогын хүрээнд орон нутгийн өмчийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Газар нь дараах асуудлыг аймгийн Засаг даргаар уламжлуулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.
 - 2.3.1. Орон нутгийн өмчийн бодлого чиглэлийг боловсруулж хэрэгжүүлэх
 - 2.3.2. Орон нутгийн өмчийн хөрөнгийг хувьчилж үл болох хөрөнгийн жагсаалтыг гаргаж хэрэгжилтэд нь хяналт тавих
 - 2.3.3. Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалт, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам боловсруулж батлуулах
 - 2.3.4. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх

2.3.5. Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох саналыг боловсруулах

2.3.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам боловсруулж батлуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих

2.3.7. Орон нутгийн өмчөөс хувьчлагдах хөрөнгийн жагсаалтыг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн гаргаж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах

2.3.8. Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, аж ахуй нэгжийн хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулалт оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх

2.3.9. Орон нутгийн өмчийг засварлах шинээр олж авах хөрөнгийн жагсаалт гаргаж түүний эх үүсвэрийн тухай санал боловсруулан шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах

2.3.10. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам боловсруулан батлуулж хэрэгжүүлсэн ажиллах

2.3.11. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох санал боловсруулж шийдвэрлүүлэх

2.3.12. Орон нутгийн өмчийн оролцоотой байгууллага, аж ахуй нэгжид өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх

2.4. Орон нутгийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулах талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх

2.5. Орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсаны орлогыг зохих дансанд төвлөрүүлэх

2.6. Орон нутгийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг бэлтгэх, тайлагнах

2.7. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг аймгийн ИТХ-ийн хуралдаанд танилцуулж, үндсэн хөрөнгийн дүнг баталгаажуулах.

2.8. Орон нутгийн өмчит байгууллага, аж ахуй нэгжээс эд хөрөнгийн тооллого явуулах, анхан шатны бүртгэлийг хөтлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих

2.9. Орон нутгийн эзэмшилд ашиглалтгүй байгаа өмчийг хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, асуудлыг шийдвэрлүүлэх

2.10. Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлахад санал өгөх, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, зээл тусламж, хандиваар бий болсон орон нутгийн өмчийг хүлээн авах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах.

2.11. Орон нутгийн удирдлагыг өмчийн талаарх мэдээ, мэдээллээр хангах

ГУРАВ. АЛБАНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргаар, төсвийг аймгийн ИТХ-аар батлуулж, орон нутгийн төсөв болон өөрийн орлогоос санхүүжүүлнэ.

3.2. Газар нь зохих журмын дагуу хийсэн тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, Төрийн санд харилцах данстай, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл гаргаж, албан хэрэгцээний унаа, өрөө тасалгаатай байна.

3.3. Газрын даргыг томилох, чөлөөлөх асуудлыг Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль, журамд заасны дагуу аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

3.4. Газрын ажилтныг байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

3.5. Газар нь ажлаа аймгийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

3.6. Газар нь өөрийн чиг үүрэг, зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалт, зардлын тооцоог Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлнэ.

3.7. Газрын үйл ажиллагааны санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гарган аудитаар баталгаажуулан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст өгнө.

3.8. Ажлын эрх ашигт нийцүүлэн ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж, шуудан холбоо, унааны зардал бусад хангамжийн асуудлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

3.9. Орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын материал, хувьчилсан, худалдсан, шилжүүлсэн хөрөнгийн жагсаалтыг төрийн архивт тухай бүр шилжүүлж байна.

3.10. Газар нь орон нутгийн өмчийн бодлого чиглэлийн талаар төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс мэргэжил арга зүйн туслалцаа авч, хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцож байна.

3.11. Газар нь үйл ажиллагаандаа улирал тутам Санхүү, төрийн сангийн хэлтсээр, жилдээ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээр хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны
11 сарын 13 өдрийн А/764 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ОРОН ТОО,
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

д/д	Албан тушаалын нэршил	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1.	Орон нутгийн өмчийн газрын дарга	Удирдах	Ахлах түшмэл, ТЗ-4	
2.	Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	
3.	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	
4.	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	
5.	Өмчийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	
6.	Хөрөнгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	
7.	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	
8.	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	
9.	Хууль, хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	
10.	Нягтлан бодогч	Гүйцэтгэх	ТҮ-7	
11.	Архив, бичиг хэргийн ажилтан	Гүйцэтгэх	ТҮ-5	
12.	Нярав, жолооч	Гүйцэтгэх	ТҮ-4	
	Нийт орон тоо			